



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 01 сарын 18 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

**Мэдээллийн аюулгүй байдлыг
ханган ажиллах тухай**


Эрүүл мэндийн салбарын цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2013 оны 05 сарын 14-ний өдрийн А/477 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 12 сарын 25-ны 11 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус төвийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг шинэчлэн боловсруулж, албан даалгаврын хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажил зохион байгуулж, долоо хоног бүрийн баасан гаригт Эрүүл мэндийн төвийн даргад танилцуулж байхыг Мэдээлэл технологийн албаны дарга /А.Амартөвшин/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан орлогч дарга /Ц.Тулга/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын
2019 оны 01 дугаар сарын 18-ны өдрийн
А/07 тоот тушаалын хавсралт

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАН АЖИЛЛАХ АЛБАН ДААЛГАВАРЫН
ХҮРЭЭНД ХИЙГДЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2019 оны 01 дүгээр сарын 10

Улаанбаатар хот

№	Хэрэгжүүлэх ажил	Хариуцах эзэн
1	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журмыг шинэчлэн боловсруулах;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
2	Байгууллагын сервер компьютер, дотоод, гадаад сүлжээний орчинд мэргэжлийн байгууллагаар аудит хийлгэх;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
3	Байгууллагын сервер компьютерын нууц үгийг тогтсон хугацаанд сольж хэвших, гадаад хандалтыг бүрэн хаах;	Мэдээллийн технологийн ажилтан Э.Тамир
4	Байгууллагын серверийн өрөөний хаалганд тусгай код, хурууны хээгээр онгойдог цоожтой болгох;	Аж ахуйн албаны дарга Б.Золзаяа
5	Хяналтын камер байршуулах, өрөөнд орсон, гарсан цаг, минут, хийсэн үйлдэл бүрийг бүртгэх, хөтлөх;	Мэдээллийн технологийн ажилтан Э.Тамир
6	Гадны хүн байгууллагын серверийн өрөөнд орох, серверийн компьютерт хандах, хэрэглэгчийн компьютер ашиглах, сүлжээнд холбогдохыг хориглох;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
7	Е-Health болон бусад эмнэлгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа програм хангамжийн шинэчлэлийг гүйцэтгэгч байгууллагаар хийлгэхдээ НЭМГ-т урьдчилан мэдэгдэж, байгууллагын орчинд мэдээллийн технологийн ажилтаны хяналтан дор хийлгэх, хийсэн ажлын тэмдэглэл хөтлөх;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
8	Дотоод сүлжээнд wifi технологиор холбогдож байгаа бүх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдийн холболтыг сүлжээний кабельд шилжүүлж шинэчлэх;	Мэдээллийн технологийн ажилтан Э.Тамир
9	Эмнэлгийн мэдээллийн систем ажиллаж байгаа сүлжээг интернэтээс тусгаарлах, wifi цацагч ашиглахыг хориглох;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
10	Мэдээллийн технологийн ажилтаны ажлын чиг үүргийн дагуу үйл ажиллагаанд нь хяналт тавих, ажлын сахилга дэг журам, хариуцлагыг дээшлүүлэх;	Стратеги бодлого төлөвлөлт эрхэлсэн орлогч дарга Ц.Тулга
11	Мэдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой програм хангамж, технологи, тоног төхөөрөмж худалдан авахтай холбоотой асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх;	Ерөнхий нягтлан бодогч Д.Хишигсүрэн

12	Харъяа байгууллагуудын эмчилгээ үйлчилгээ, үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн яамнаас зөвшөөрөгдсөнөөс бусад програм хангамж нэвтрүүлэхийг хориглоно;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
13	Эрүүл мэндийн яамны 2018 оны 12 сарын 19-ны 5/5132 тоот албан даалгаврын дагуу байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр шаардлагатай ажлыг зохион байгуулж долоо хоног бүрийн баасан гаригт хавсралтын дагуу холбогдох и-мэйл хаягаар тогтмол хүргүүлэх;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин
14	Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 12 дугаан сарын 25 өдрийн 11 тоот албан даалгаврын хүрээн хийсэн ажлын тайланг улирал бүр дээд шатны байгууллагад хүргүүлэх;	Мэдээлэл технологийн албаны дарга А.Амартөвшин